



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 09 сарын 15 өдөр

Дугаар 8/08

Жаргалтхаан сум


С.Мөнхдэлгэрт сахилгын шийтгэл
ногдуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.3 дахь заалт, Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 36/32 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журам"-ын 1.3.3, 1.5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газраас Засаг даргын Тамгын газрын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн гүйцэтгэлийн аудитаар тогтоосон албан шаардлагын биелэлтийг хангаж ажиллаагүй, дээрх алдаа дутагдлыг дахин давтан гаргасан Засаг даргын Тамгын газрын дарга Сэсээрийн Мөнхдэлгэрт сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2.Цаашид аудитын шалгалтаар илэрсэн алдаа, зөрчлийг дахин гаргахгүй байх, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга С.Мөнхдэлгэрт үүрэг болгосугай.

ДАРГА



С.ГАНБАТ